

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/90/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Эрдэнэцэцэг Утас: 70432545 цахим хаяг: ErdenetsetsegD@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>АЗДТГ</i>	<i>Аймгийн Засаг даргын тамгын газар</i>
<i>НДШ</i>	<i>Нийгмийн даатгалын шимтгэл</i>
<i>ХАОАТ</i>	<i>Хүн амын орлогын албан татвар</i>
<i>ЗДТГ</i>	<i>Засаг даргын тамгын газар</i>
<i>СТСХ</i>	<i>Санхүү, Төрийн сангийн хэлтэс</i>
<i>АХО</i>	<i>Аймгийн хөрөнгө оруулалт</i>
<i>ТХОТСХТ</i>	<i>Төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт хийх, тайлагнах</i>

Агуулга

1.Төрийн аудитын байгууллагын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	14
3. Аудитын тайлан	14
3.1. Ерөнхий зүйл	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	15
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	17
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	
Аудитын зөвлөмж	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	18
4. Менежментийн захидал	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

1.ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061 Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2021.03.22 № 4/173
тантай _____ -ийм № _____ -т

ХОВД АЙМГИЙН ЗДТГ-ЫН
ДАРГА Д.ЭНХБОЛД ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, үр дүнгийн тайлан, гэрээний биелэлт, ирээдэд хүргэх мэдээллийн бодит байдал зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

021020724

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,411,523,943.97	1,258,409,436.24
33	АВЛАГА	828,506,556.00	483,391,314.97
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,100,000.00	1,100,000.00
335	Бусад авлага	827,406,556.00	482,291,314.97
3351	Байгууллагаас авах авлага	827,406,556.00	482,291,314.97
34	УРЬДЧИЛГАА	384,293,607.00	379,933,578.00
34600	Урьдчилж гарсан зардал	379,734,207.00	378,159,478.00
3471	Урьдчилгаа тооцоо	4,559,400.00	1,774,100.00
34713	Цалингийн урьдчилгаа	4,559,400.00	1,774,100.00
35	БАРАА МАТЕРИАЛ	116,373,243.97	165,823,873.27
354	Хангамжийн материал	86,958,243.97	143,503,993.97
35410	Бичиг хэргийн материал	2,293,000.00	2,913,000.00
35420	Аж ахуйн материал	786,000.00	954,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	13,184,612.00	14,820,712.00
35450	Барилгын засварын материал	9,490,050.00	52,363,300.00
35470	Бусад хангамжийн материал	61,204,581.97	72,452,981.97
35600	Мал амьтад	29,415,000.00	22,319,879.30
36	НӨӨЦИЙН БАРАА	82,350,537.00	229,260,670.00
36100	Барааны нөөц	7,919,950.00	170,388,470.00
36300	Тэжээлийн нөөц	74,430,587.00	58,872,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,101,822,531.38	4,021,313,538.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,101,822,531.38	4,021,313,538.90
392	Биет хөрөнгө	3,389,135,993.85	3,309,142,938.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,922,677,859.00	3,135,105,091.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(113,726,174.16)	(243,185,249.96)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	610,124,024.00	510,624,024.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(355,351,572.73)	(400,984,303.87)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	361,610,312.90	388,059,012.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	(280,842,519.24)	(305,602,655.12)

39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	268,082,347.52	279,074,597.52
39208	Хуримтлагдсан элэгдэл	(190,382,237.66)	(209,056,345.60)
39209	Зам, гүүрийн байгууламж	253,736,906.07	253,736,906.07
39210	Хуримтлагдсан элэгдэл	(90,589,047.96)	(109,585,709.88)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	3,889,700.00	12,189,700.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	(93,603.89)	(1,232,128.35)
393	Биет бус хөрөнгө	712,686,537.53	712,170,600.19
39301	Програм хангамж	17,886,115.00	17,886,115.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(15,999,177.47)	(16,515,114.81)
39303	Бусад биет бус хөрөнгө	710,799,600.00	710,799,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,513,346,475.35</u>	<u>5,279,722,975.14</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,513,346,475.35</u>	<u>5,279,722,975.14</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,513,346,475.35	5,279,722,975.14
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон	2,829,163,598.00	2,829,163,598.00
51101	Өмч: - төрийн	2,829,163,598.00	2,829,163,598.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,526,246,050.67	1,292,622,550.46
51210	Өмнөх үеийн үр дүн	1,526,246,050.67	1,526,246,050.67
51220	Тайлант үеийн үр дүн	-	(233,623,500.21)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,157,936,826.68	1,157,936,826.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5,513,346,475.35</u>	<u>5,279,722,975.14</u>

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,908,064,282.36	4,490,262,681.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	167,321,870.00	399,035,073.00
120	Нийтлэг татварын бус орлого	167,321,870.00	399,035,073.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	167,321,870.00	399,035,073.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,660,520.00	17,389,716.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	144,661,350.00	381,645,357.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,740,742,412.36	4,091,227,608.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	247,928,503.00	-
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	34,680,000.00	-

131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	213,248,503.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,718,747,864.36	829,766,256.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	400,447,111.36	37,895,830.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,680,000.00	430,978,448.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,005,792,686.00	288,456,982.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	277,828,067.00	72,434,996.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,773,646,400.00	3,261,461,352.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,773,646,400.00	2,043,952,800.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт		74,405,405.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/		639,220,827.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		503,882,320.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	419,645.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	419,645.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,936,241,850.96	4,628,532,014.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,936,241,850.96	4,628,532,014.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,853,811,832.96	4,492,660,057.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	885,483,600.12	994,859,308.00
210101	Үндсэн цалин	452,948,818.00	470,167,915.96
210102	Нэмэгдэл	140,485,867.43	218,616,784.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,873,191.00	15,452,900.00
210105	Гэрээт ажлын хөлс	273,175,723.69	290,621,708.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,488,388.24	129,626,900.00
210201	Тэтгэврийн даатгал	70,040,877.71	93,219,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,921,363.12	9,068,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,295,994.49	7,681,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,073,998.63	1,920,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,156,154.29	17,736,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	260,606,950.19	247,387,326.00
210301	Гэрэл, цахилгаан	36,528,276.00	44,920,268.00
210302	Түлш, халаалт	203,549,374.19	179,239,498.00
210303	Цэвэр, бохир ус	20,529,300.00	23,227,560.00
2104	Хангамж, бараа материалын зардал	101,942,916.14	142,206,817.08

210401	Бичиг хэрэг	28,201,200.00	21,186,315.00
210402	Тээвэр, шатахуун	47,783,097.14	68,980,691.08
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,512,869.00	14,716,079.00
210404	Ном, хэвлэл	7,317,500.00	1,393,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	810,000.00	591,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	205,250.00	716,800.00
210408	Бараа материал акталсны зардал	113,000.00	34,622,632.00
2105	Нормативт зардал	5,823,430.00	2,821,400.00
210502	Хоол, хүнс	485,400.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,338,030.00	2,821,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,604,374.93	23,327,960.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,936,000.00	3,459,500.00
210604	Урсгал засвар	33,668,374.93	19,868,460.00
2107	Томилолт, зочны зардал	51,331,800.00	15,214,900.00
210702	Дотоод албан томилолт	51,331,800.00	15,214,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,410,432,759.43	1,217,494,311.61
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,402,558,686.43	1,209,524,028.61
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,078,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,662,140.00	2,759,190.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	929,409.00	1,204,213.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	269,000.00	250,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,730,000.00	1,633,480.00
210807	Газрын төлбөр	275,524.00	1,045,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,006,097,613.91	1,719,721,134.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	749,125,653.24	1,487,094,856.04
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,600,000.00	1,723,146.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	253,371,960.67	230,903,132.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,430,018.00	135,871,957.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,655,838.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,655,838.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,764,170.00	135,551,679.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	704,170.00	90,679.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	128,693,000.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,060,000.00	6,768,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	120,858.00	320,278.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	120,858.00	320,278.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	67,889,152.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	67,889,152.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>971,822,431.40</u>	<u>(138,269,333.53)</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	(99,500,000.00)
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз		(99,500,000.00)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	(4,145,833.32)
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	(4,145,833.32)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(95,354,166.68)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>971,822,431.40</u>	<u>(233,623,500.21)</u>

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>4,914,177,627.36</u>	<u>4,126,063,041.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,835,520.00	33,311,646.00
120	Нийтлэг татварын бус орлого	23,835,520.00	33,311,646.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,680,520.00	33,311,646.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,680,520.00	33,311,646.00
120009	Бусад орлого	5,155,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,890,342,107.36	4,092,751,395.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	247,928,503.00	-
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	34,680,000.00	-
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	213,248,503.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,868,347,559.36	831,098,710.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	400,447,111.36	37,895,830.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,680,000.00	430,978,448.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,018,292,686.00	288,456,982.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	414,927,762.00	73,767,450.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,773,646,400.00	3,261,461,352.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,773,646,400.00	2,043,952,800.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт		74,405,405.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/		639,220,827.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		503,882,320.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	419,645.00	191,333.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	419,645.00	191,333.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,914,177,627.36	4,126,063,041.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,914,177,627.36	4,126,063,041.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,230,722,782.36	3,753,056,908.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	866,180,892.36	994,859,308.00
210101	Үндсэн цалин	525,102,147.00	470,167,915.96
210102	Нэмэгдэл	73,612,900.00	218,616,784.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,234,285.00	15,452,900.00
210105	Гэрээт ажлын хөлс	245,231,560.36	290,621,708.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,854,448.00	129,626,900.00
210201	Тэтгэврийн даатгал	106,047,377.00	93,219,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,859,970.00	9,068,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,046,800.00	7,681,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	261,600.00	1,920,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,638,701.00	17,736,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	254,956,448.00	254,677,100.00
210301	Гэрэл, цахилгаан	36,901,776.00	47,030,300.00
210302	Түлш, халаалт	197,525,372.00	180,789,500.00
210303	Цэвэр, бохир ус	20,529,300.00	26,857,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	100,176,699.00	119,843,900.00
210401	Бичиг хэрэг	17,614,660.00	20,053,200.00
210402	Тээвэр, шатахуун	61,079,885.00	73,511,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,265,454.00	16,343,400.00
210404	Ном, хэвлэл	1,406,700.00	1,441,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	810,000.00	840,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	7,653,800.00
2105	Норматив зардал	3,223,830.00	2,720,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,223,830.00	2,720,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,056,745.00	46,852,400.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	3,589,090.00	9,356,900.00
210604	Урсгал засвар	40,467,655.00	37,495,500.00
2107	Томилолт, зочны зардал	50,016,800.00	16,216,800.00
210702	Дотоод албан томилолт	50,016,800.00	16,216,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,953,469,044.00	611,167,134.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,928,459,971.00	600,034,234.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,692,140.00	2,800,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	929,409.00	1,237,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	269,000.00	250,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,000,000.00	4,000,000.00
210807	Газрын төлбөр	275,524.00	1,045,400.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	15,835,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	846,787,876.00	1,577,093,366.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	842,787,876.00	1,573,093,366.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,000,000.00	4,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	683,454,845.00	373,006,133.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,655,838.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,655,838.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,568,170.00	135,783,679.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	7,508,170.00	90,679.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	128,693,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,060,000.00	7,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	594,341,685.00	237,222,454.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	594,341,685.00	237,222,454.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	67,889,152.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	67,889,152.00	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,829,163,598.00	1,157,936,826.68	1,526,246,050.67	5,513,346,475.35
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,829,163,598.00	1,157,936,826.68	1,526,246,050.67	5,513,346,475.35
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,829,163,598.00	1,157,936,826.68	1,526,246,050.67	5,513,346,475.35
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,829,163,598.00	1,157,936,826.68	1,526,246,050.67	5,513,346,475.35
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,829,163,598.00	1,157,936,826.68	1,526,246,050.67	5,513,346,475.35
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(233,623,500.21)	(233,623,500.21)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,829,163,598.00	1,157,936,826.68	1,292,622,550.46	5,279,722,975.14

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,060,952,800	2,060,632,522
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,060,952,800	2,060,632,522
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,925,259,800	1,924,939,522
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	961,536,846	961,536,846
210101	Үндсэн цалин	470,167,916	470,167,916
210102	Нэмэгдэл	218,616,784	218,616,784
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,452,900	15,452,900
210105	Гэрээт ажлын хөлс	257,299,246	257,299,246
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,626,900	129,626,900
210201	Тэтгэврийн даатгал	93,219,400	93,219,400
210202	Тэтгэмжийн даатгал	9,068,800	9,068,800
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,681,600	7,681,600
210204	Ажилгүйдлийн даатгал	1,920,400	1,920,400
210205	Эрүүл мэндийн даатгал	17,736,700	17,736,700
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	254,677,100	254,677,100
210301	Гэрэл, цахилгаан	47,030,300	47,030,300
210302	Түлш, халаалт	180,789,500	180,789,500

210303	Цэвэр, бохир ус	26,857,300	26,857,300
2104	Хангамж, бараа материалын зардал	120,951,276	119,843,900
210401	Бичиг хэрэг	20,053,200	20,053,200
210402	Тээвэр, шатахуун	74,618,976	73,511,600
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,343,400	16,343,400
210404	Ном, хэвлэл	1,441,900	1,441,900
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	840,000	840,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,653,800	7,653,800
2105	Нормативт зардал	2,720,000	2,720,000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,720,000	2,720,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,852,400	46,852,400
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,356,900	9,356,900
210604	Урсгал засвар	37,495,500	37,495,500
2107	Томилолт, зочны зардал	16,216,800	15,344,176
210702	Дотоод албан томилолт	16,216,800	15,344,176
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,756,700	59,736,700
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,623,800	48,603,800
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,800,000	1,800,000
210803	Даатгалын үйлчилгээ	2,800,000	2,800,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,237,500	1,237,500
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	250,000	250,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,000,000	4,000,000
210807	Газрын төлбөр	1,045,400	1,045,400
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	334,921,778	334,601,500
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	330,921,778	330,601,500
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,000,000	4,000,000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	135,693,000	135,693,000
2132	Бусад урсгал шилжүүлэг	135,693,000	135,693,000
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	128,693,000	128,693,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,000,000	7,000,000
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,060,952,800	2,060,632,522
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,043,952,800	2,043,632,522
132001	Орон нутгийн төсвөөс	2,043,952,800	2,043,632,522
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	17,000,000	17,000,000

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,000,000	17,000,000
---------	---	------------	------------

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,819,923,732.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,819,923,732.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,819,923,732.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	35,380,075.00
210105	Гэрээт ажлын хөлс	35,380,075.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	504,087,899.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	504,087,899.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,280,455,758.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,280,455,758.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,819,923,732.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,819,923,732.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	100,645,830.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	674,919,144.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	364,675,248.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	679,683,510.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3.АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг тамгын газрын дарга Д.Энхболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагын шүүхийн шийдвэрээр олгосон зардалтай холбоотой өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-ноос 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Эрдэнэцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Төр, иргэн, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаанд тулгуурлан, хүний хөгжлийг ханган, төрийн албыг чадавхжуулж, иргэд, үйлдвэрлэл бизнест ээлтэй, ногоон хөгжлийн **АЙМАГ** болохын төлөө нутгийн захиргааны байгууллагуудыг манлайлан ажиллана гэсэн зорилт тавин ажилласан байна. Байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь:

- ✓ Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангаж, төрийн албаны үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлж, сайн засаглалыг бэхжүүлэх

- ✓ Хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн нийгмийн цогц үйлчилгээг зорилтод бүлгүүдэд шуурхай хүргэх
- ✓ Үйлдвэрлэл, бизнест ээлтэй орчин бүрдүүлсэн эдийн засгийн өсөлтийг дэмжиж орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг бий болгох
- ✓ Хүн амьдрах эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгалийн нөөц баялгаа хамгаалах, зүй зохистой ашиглах замаар ногоон хөгжлийн загвар хот болох

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Аймгийн Засаг даргын тамгын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор Төр, захиргааны байгууллагын дотоод хяналт болон бусад хяналтын байгууллагууд 2020 онд тус байгууллагад хяналт хэрэгжүүлээгүй ч аймгийн Төрийн сангаас өдөр тутмын санхүүгийн гүйлгээнд дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаа, санхүүд хэрэгжүүлсэн дотоод хяналтын тайлан мэдээ байхгүй байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинд “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 4069551.5 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 40695.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 4663283.2 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 46632.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 233623.6 мянган төгрөгөөр буюу 16.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
АВЛАГА	1,212,800.2	863,324.9	-349,475.3
БАРАА МАТЕРИАЛ	198,723.8	395,084.5	196,360.7
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,101,822.5	4,021,313.5	-80,509.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,513,346.5	5,279,722.9	-233,623.6
БОГИНО ХУГАЦААТ ӨР	0.0	0.0	0.0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН	5,513,346.5	5,279,722.9	-233,623.6
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР	5,513,346.5	5,279,722.9	-233,623.6

Авлага дансны үлдэгдэл оны эцэст 863324.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Аж ахуйн нэгж байгууллагуудтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулсан. Ажилчидтай холбогдох шимтгэлийн тооцоо, цалинтай холбоотой тооцоог татвар, даатгалын байгууллагатай тооцоо хийж тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна. Өмнөх оноос авлага 349475.3 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь урьдчилж гарсан хөрөнгийн зардал буурсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 395084.5 мянган төгрөг болж 196360.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үнэ төлбөргүй орлогоор хүлээн авсан хандивын орлого нэмэгдэж бараа материалын худалдан авалт өссөн байгаа нь нөлөөлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 4101822.6 мянган төгрөг, оны эцэст 4021313.6 мянган төгрөг болж 80509.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн данс нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 36974.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжтэй холбоотой хөрөнгө, Аймгийн хөрөнгө оруулалтаас 208773.4 мянган төгрөгийн хөрөнгийг 2020.12.09-ны „, тоот аймгийн ИТХ-ын тогтоолоор үнэ төлбөргүй орлогоор авч, 90500.0 мянган төгрөгийн хөрөнгө аймгийн ИТХ-ын 2020.12.14-ны 00 тоот тогтоолоор данснаас дансанд шилжүүлж тайлагнасан байна. Тайлант онд бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого хийсэн байна.

Өр төлбөр оны эхэнд өрийн үлдэгдэлгүй байна. Тайлант онд үүссэн өглөг бүрэн барагдуулж өр төлбөр үүсгээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл оны эцэст 5279722.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Оны эхнээс 233623.6 мянган төгрөгийн тайлант үеийн үр дүнгээр буурсан байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 417801.6 мянган төгрөгөөр буюу 18.8 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 417801.6 мянган төгрөгийн орлогын өөрчлөлтөөс дээд шатны захирагчаас авах хөрөнгө 417801.6 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 731187.2 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт дансаар өмнөх оны үлдэгдлээс санхүүжсэн хөрөнгийн зардал өссөнтэй холбоотой байна

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү бодлогын өөрчлөлтөөр бүртгэлийн бичилт хийгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 2097952.8 мянган төгрөгөөр нийт зарлагыг 2097952.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн төсвөөс үндсэн үйл ажиллагааны зардалд төсвөөс 2043952.8 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлогоос 17000.0 мянган төгрөгөөр нийт 2060952.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2060952.8 мянган төгрөгийн төсөв баталснаас төсвөөс 2043952.8 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 17000.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2060952.8 мянган төгрөгийн төсөв баталснаас төсвөөс 2043952.8 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 17000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч 2060632.5 мянган төгрөг зарцуулж 320.3 мянган төгрөгийн төсвийн хэмнэлт гарган төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2060632.5 мянган төгрөг буюу 99% зарцуулсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийн 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн боловч хөтөлбөрөөс хэмнэлт гаргасан байна.

Хөтөлбөр арга хэмжээний хэмнэлтийг хүснэгтээр харуулбал:

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	320.3
	ДҮН	320.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар аймгийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтын санхүүжилт ЗГ-ын хэрэг эрхлэх газраас багийн хөгжлийн санхүүжилт 301303.2 мянган төгрөг, ОНХС-ийн санхүүжилт 503882.3 мянган төгрөг, төсөл хөтөлбөрөөс 63200.0 мянган төгрөг, хандив тусламжийн орлогоос 37895.8 мянган төгрөг, Засаг дарга данснаас 145461.3 мянган төгрөг Хөшөөт хөгжил сангаас 73463.2 мянган төгрөг, БОАЖС-ын багцаас 40000,0 мянган төгрөг, нэмэлт үйл ажиллагааны орлогоос 74405.4 мянган төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 639220.8 мянган төгрөг, ОНХО-аас 65000.0 мянган төгрөг, бусад үйл ажиллагааны нэмэлт орлогоос 112903.9 мянган төгрөг нийт 2056825.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Нэмэлт орлогоос БОАЖС-ын хог менежмент хэрэгжүүлэх санхүүжилт 247816.9 мянган төгрөг, архивын гэрээт ажилчдын цалинд 25485.4 мянган төгрөг, Засаг даргын захирамжаар хөрөнгө оруулалт 354909.9 мянган төгрөг, багийн хөгжлийн санхүүжилт 170871.9 мянган төгрөг, өвс тэжээлийн үнэд 13443.9 мянган төгрөг, төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын санхүүжилт 331674.4 мянган төгрөг, эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтаар 675721.3 зарцуулж 236902.2 мянган төгрөгийн төсөвт буцаан төвлөрүүлж авлагаар тусгасан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 138 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 136, оруулаагүй мэдээлэл 1 байна., хугацаа хоцроосон 1 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулахаас 1 мэдээллийг байршуулаагүй байгааг залруулан мэдээллийг орууллаа.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Аймгийг Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт гаргаж дараах төлбөрийн акт, зөвлөмжийг өгсөн байна. Хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	13,671.7	1	13,671.7		-	100
Албан шаардлага	1	143,086.9	-	-	1	143,086.9	-
Зөвлөмж	4	21,064.9	4	21,064.9	-	-	100
Нийт дүн	6	177,823.5	5	34,736.6	1	143,086.9	67

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар 79836.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс залруулсан алдаа зөрчил байхгүй, 79836.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчлөөс 79636.6 мянган төгрөгийн 1 зөрчилд 1 зөвлөмж өгч акт, албан шаардлага бичигдээгүй.

Залруулсан алдаа: Аудитаар тайлангийн аудитаар залруулга хийгдсэнгүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар акт албан шаардлага бичигдсэнгүй.

Аудитын зөвлөмж: Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 79636.6 мянган төгрөгийн 1 алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Тус байгууллагын санхүүгийн тайланг баталгаажуулах явцад цаг хугацааны хувьд давчуу байсан тул засаг даргын захирамжийн хэрэгжилт, эрх шилжиж ирж байгаа хөрөнгийн зарцуулалт, зарим зардлыг аймгийн нэгдсэн тайлангаар авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө

- 1.1. Илрүүлэлт: Засаг даргын 2020/11/20-ны А/711 тоот захирамжаар Шүүхийн шийдвэрийн дагуу иргэнд нөхөн төлбөр олгож төсвийн үргүй зардал гаргасан 79636.6 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.
- 1.2. Эрсдэл: Дотоод хяналтын үр дүнг хэрэгжүүлээгүй байх, төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдсан байх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх
- 1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах, Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих 50.1-д “Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ, 50.2-д Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана. Захиргааны ерөнхий хуулийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах
- 1.4. Байгууллагаас ирүүлсэн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Аймгийн ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/90/СТА-ТШЗТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Аймгийн ЗДТГ		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5

1	Төрийн албан хаагчдад Шүүхийн шийдвэрээр нөхөн төлбөр олгож төсвийн үргүй зардал гаргасан	79836.6	Зөвлөмж		
ДҮН		79836.6			

ХОВД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР